



БОДЛОГЫН ТОЙМ: ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ӨР БА ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2004 î î 9 äçäýýä ñàä



Оршил

Монгол улсын нийт өр ДНБ-ий түвшинд буюу 2004 оны байдлаар 1.3 тэрбумд хүрнэ гэсэн тооцоо гарсан байна. Үүний бараг тэн хагас нь эрчим хүчний салбарт хамаатай ба энэ салбарт цаашдаа олон улсын байгууллагуудаас зээл үргэлжлүүлэн авах хандлагатай байна. Эдгээр зээлийн дийлэнхийг хөнгөлөлттэй нөхцлөөр авсан бөгөөд Монгол улсын шилжилтийн үеийн “харанхуйд даарах” хүнд байдлаас гэтэлгэх зорилгоор олгогдож үр дүнгээ өгч байсан билээ. Харин одоо тэрхүү шилжилтийн хүнд бэрх цаг өнгөрсөн учраас Монгол улсын эрчим хүчний салбарын ажил үйлчилгээг өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх замаар улсын өрийг цаашид нэмэгдүүлэхгүй байх тал дээр онцгой анхаарал тавих цаг тулгарч ирээд байна.

Эрчим хүчний салбарт авсан зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа нь дуусч байгаагаас үндсэн зээл болон хүүгийн төлбөр улсын төсөвт болон эрчим хүчний компаниудад хүнд дарамт болох юм. Нэмэгдэж буй зээлийн хэмжээ нь тус улсын бие даасан байдал болон улс орны ерөнхий эрсдлийн үнэлгээнд сөргөөр нөлөөлөх юм. Хэдийгээр улс төрийн эрсдлийн хэмжээ бага байгаа боловч хөрөнгө оруулагчид болон эрсдлийн үнэлгээний байгууллагууд Монгол улсыг доорх үзүүлэлтээр өндөр эрсдэлтэй орны тоонд оруулж байна. Эдгээр нь:

- Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь
- Гадаад актив импортын сараар
- Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь
- Урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

Монгол улсын санхүүгийн болон эдийн засгийн эрсдэл нь “маш өндөр” байгаа нь Монгол улсад хийх хөрөнгө оруулалтын эрсдлийн шагналыг ихэсгэж байна: Ингэснээр МУ-ын ЗГ-г зээлэх зээлийн хүү өндөр байх--Монгол улс олон улсын өрийн зах зээлд өндөр--Хөрөнгө оруулагчдаас Монгол улсад хөрөнгө оруулахад эрсдлийн шагнал өндөр байх тусам Монгол улсад илүү их зардалтай байх болно гэсэн үг юм. Жишээ нь: 30 жилийн хугацаатай 50 сая ам.долларын хөрөнгө оруулалтын эрсдлийн шагналын хувийг 100 нэгж буюу 1%-иар бууруулбал хөрөнгө оруулалтын зардал 9.8 сая доллараар багасна гэсэн үг. Олон улсын хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын эрсдлийн хэмжээ багатай улс орныг сонирхох нь ойлгомтой.

Макро эдийн засгийн эдгээр хүндрэлтэй байдлуудаас авч үзэхэд Монголын эрчим хүчний салбарын үйлчилгээний чанар, хамрах хүрээг сайжруулахдаа цаашид гадаад зээлийн эх үүсвэрээр шийдээд байх боломжгүй юм. Харин төрөөс доорх зохицуулалтуудыг хийж, дотоодын болон гадаадын хувийн хөрөнгө оруулалтыг татахын тулд зохистой шагнал, урамшууллын тогтолцоог бий болгох тал дээр анхаарах нь зүйтэй. Эдгээр зохицуулалтуудад:

- Гадаад өр, өр барагдуулалтаас төсөвт үзүүлж буй дарамт, улс орны ерөнхий эрсдлийн хэмжээг багасгах
- Эрчим хүчний салбарт эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд шууд оролцдоогоо больж, зохицуулт хийх
- Эрчим хүчний салбарын байгууллагуудын техник, технологи, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах
- Байгаль орчинд үзүүж буй хор нөлөөг багасгах

Эрчим хүчний салбарт явуулах бодлого нь дараах зорилтуудад чиглэсэн байх нь зохистой:

1. Салбарын хөрөнгө оруулалтыг гадаад зээлээр бус хувийн хэвшлийн санхүүжилтээр сольж, үйлчилгээний чанар хамрах хүрээг сайжруулан, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, эдийн засаг дахь төрийн оролцоог зохицуулагчын тогтолцоонд шилжүүлэх.
2. Эрчим хүчний болон бусад салбаруудын дэд бүтцийн санхүүжилтийн асуудлыг шийдэхэд дотоодын болон гадаадын хувийн хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор Концессийн гэрээний хуулийг боловсруулж батлах. Ингэснээр төрийн өмчийн хөрөнгийг 100% худалдахыг бодвол илүү эрсдэл багатай аргаар шийдвэрлэж болно.
3. Хөрөнгө оруулагчдын эрсдлийг багасгах зорилгоор эрчим хүчний салбарын хууль дүрмүүдийг шинэчлэн сайжруулж, хөрөнгө оруулагчдын зүгээс тухайн улс орны эрх зүйн байдалд дүн шинжилгээг хийж, зохих сувгуудаар болон хөрөнгө оруулагчдад хандсан шоу хөтөлбөрүүдээр эдгээр өөрчлөлт шинэчлэлтүүдээ сурталчлан таниулах.
4. Урсгал тэнцэл, гадаад активыг нэмэгдүүлэх, гадаад өр, улсын төсвийн алдагдлыг багасгахад чиглэсэн макро эдийн засгийн нэгдмэл бодлого зохицуулалтыг хийх. Үүгээр дамжуулж хөрөнгө оруулагчдад шаардагдах улс орны эрсдлийн үнэлгээний рейтингээ нэмэгдүүлэхийг зорих.
5. Улсын төсөвт учруулж байгаа дарамтыг багасгахын тулд гадаад зээл авахыг түр хойшлуулах хувьчлалыг ил тодоор, дэлхийн хэмжээний томоохон компаниудыг татах хувьчлалын үйл явцад чадвартай хөрөнгө оруулалтын банкуудыг оролцуулахын тулд хангалттай хугацааны туршид төлөвлөж явуулах.

Монголын улс орны эрсдэл болон улс орны эрсдлийн шагналын талаар тодорхой мэдэхийг хүсвэл ЭЗБШӨЧ төслөөс 2004 оны 8 сард боловсруулан гаргасан “Монголын улс орны эрсдэл, улс орны эрсдлийн шагналын тайлан”-г олж үзнэ үү. Мөн хөрөнгө оруулагчдын зүгээс хувьчлалд хэрхэн хандах талаар ЭЗБШӨЧ төслийн 2004 оны 4 сард боловсруулан гаргасан “Хувьчлал: Хөрөнгө оруулагчдын зүгээс хэрхэн хандах нь” семинарын материалыг олж үзнэ үү.

Зөвлөмж

Мэдээллийн эх үүсвэр